ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД "ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ" СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 2

ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦЫН ТАЛААР ӨМГӨӨЛӨГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 4

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА 5

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

*Эрх чөлөөтэй байхын тулд хуульд захирагдах хэрэгтэй
Ж.Амарсанаа*

# Хууль зүйн мэдээ

www.nli.gov.mn | Хууль зүйн мэдээ сонин | 2022.12.01

## ЗЭЭЛИЙН ГЭРЭЭ БА ХҮҮ







## АЖЛААС ХАЛАГДСАНЫ ТЭТГЭМЖ



## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд сурагчдад “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” сэдвээр цуврал сургалт зохион байгуулдаг. Энэ удаад Налайх дүүргийн 103, 119, 109, Эрдмийн оргил цогцолбор сургууль, Голомт цогцолбор сургуулийн ахлах ангийн 320 гаруй сурагчдыг хамрууллаа. Сургалтад Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Арга зүйч багш Д.Цэцэгдарь, Сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заав.









## ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАГЧДАД “ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ” СЭДВЭЭР СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүй, дотоод хэргийн сайдын нэрэмжит эрдэм шинжилгээний шилдэг бүтээл, илтгэл, грант олгох төслийн уралдааны шилдгүүдэд шагнал гардуулах ёслол өнөөдөр боллоо. Тус уралдааныг Хууль зүй, дотоод хэргийн сайдын санаачилгаар 2021 оноос зохион байгуулж эхэлсэн бөгөөд Хууль зүйн үндэсний хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль хамтран ажиллав.

Шагнал гардуулах ёслолын үйл ажиллагаанд Монгол Улсын Их Хурал, Засгийн Газрын гишүүн, ХЗДХ-ийн сайд Х.Нямбаатар, ХЗДХ-ийн сайдын зөвлөх, Монгол Улсын Төрийн соёрхолт, Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, хууль зүйн шинжлэх ухааны доктор, академич, МУИС-ийн эмерит профессор, С.Нарангэрэл, ХЗДХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, ХЗДХЯ-ны газар, хэлтсийн дарга нар, уралдааныг зохион байгуулагч ДХИС, ХЗҮХ-ийн удирдлага, их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын эрдэмтэн, судлаач, сонсогч, оюутнууд оролцлоо.



Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар уралдааны шагнал гардуулах ёслолын арга хэмжээг нээж хэлсэн үгэндээ “Хууль зүйн шинжлэх ухаан, аюулгүй байдал, хууль зүй, дотоод хэргийн салбарын эрдэм шинжилгээ, инновацыг хөгжүүлэх, онол, практикт тулгамдсан асуудлыг судалгаанд үндэслэн оновчтой, үр дүнтэй шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2021 онд энэхүү уралдааныг зохион байгуулж эхэлсэн. Уралдаанд ирүүлж байгаа судалгааны бүтээлүүд салбарын цаашдын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулна гэж найдаж байна” хэмээв.

Тус уралдаанд шилдэг бүтээлийн төрөлд 25, шилдэг илтгэлийн төрөлд 75, грант олгох төсөлд 32, нийт 132 бүтээл ирүүлснээс шилдгүүдээ тодруулсан байна.

## ХҮНИЙ ЭРХИЙН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦЫН ТАЛААР ӨМГӨӨЛӨГЧ НАРТ ЗОРИУЛСАН СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцын талаар өмгөөлөгч нарт зориулсан сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр ХЗҮХ-ийн Хуульчдын танхимд зохион байгууллаа. Сургалтад ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Д.Сүнжид, ХЭҮК-ын гишүүн, Хууль зүйн ухааны доктор Г.Нарантуяа нар хичээл заав. Сургалтад нийт 40 өмгөөлөгч хамрагдсан. Сургалтад хамрагдсанаар өмгөөлөгч нар мэргэжлийн үйл ажиллагаагаа хэрэгжүүлэхдээ Олон Улсын холбогдох гэрээ, конвенцыг ашиглах үндэсний хууль тогтоомж дахь зохих зүйл заалт, зохицуулалтыг эдгээртэй уялдуулж хэрэглэх талаар зохих ойлголт, мэдлэгтэй болох юм.









## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Өвөрхангай аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд “Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт”-ыг Өвөрхангай аймагт 11 дүгээр сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн ухааны доктор /PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн сургалт хариуцсан мэргэжилтэн П.Аззаяа нар хичээл заасан. Өвөрхангай аймгийн 50 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.







## "ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС" СЭТГҮҮЛД БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВЧ БАЙНА









## ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалтыг 11 дүгээр сарын 29-ний өдөр цахимаар зохион байгууллаа. Сургалтад, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Хууль зүйн ухааны Доктор /Ph.D./ Б.Батзориг, Хууль зүйн ухааны Магистр / LL.M./ Э.Туулайхүү, Хууль зүйн ухааны Магистр / LL.M./ С.Ганцэцэг, Хууль зүйн ухааны Магистр / LL.M./ Д.Цэцэгдарь бөгөөд Говьсүмбэр аймгийн 25 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.

## БАЙГАЛЬ ОРЧНЫ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛЭЭР ЭРХ ЗҮЙН ХӨТЧИЙГ ЧАДАВХЖУУЛАХ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд "Байгаль орчны хууль, эрх зүйн чиглэлээр эрх зүйн хөтчийг чадавхжуулах сургалт"-ыг цахимаар 11 дүгээр сарын 23-ны өдөр зохион байгууллаа. Сургалтад Хууль зүйн ухааны доктор / PhD/, профессор Э.Батбаяр, Хууль зүйн ухааны доктор /PhD/, дэд профессор А.Алтанзул, Ахлах багш С.Ганцэцэг, ХЗҮХ-ийн Арга зүйч багш Д.Цэцэгдарь нар хичээл заав. Нийслэлийн 122 эрх зүйн хөтөч хамрагдсан байна.




Хууль зүйн мэдээ
Улсын бүртгэлийн дугаар 1197
Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр хороо, Бага тойруу /15160/, Хуульчдын гудамж 1, Хууль зүйн үндэсний хүрээлэн.
11-315789
www.nli.gov.mn
Бэлтгэсэн Ц.Энхжин


ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
Та хууль зүйн зөвлөгөө, мэдээллийн 1800-1202 дугаараас дараах зөвлөгөө, мэдээллийг авах боломжтой.
Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл хаанаас авах вэ?
Гэр бүлийн харилцаа
Иргэний эрх зүй
Эрүүгийн эрх зүй
Хөдөлмөр эрхлэлт
08:30-17:30 ЦАГИЙН ХООРОНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ МЭДЭЭЛЭЛ АВАХ БОЛОМЖТОЙ.


ЭРХ ЗҮЙН ЦАХИМ ХӨТӨЧ
ТАНД ХУУЛЬ ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, МЭДЭЭЛЭЛ ХЭРЭГТЭЙ БАЙНА УУ?
Эрх зүйн хөтөч аппликейшнийг ашигласнаар хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл, төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг авах боломжтой.
ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН
ИРГЭДИЙН ОРОЛЦОО ТӨСӨЛ
QR кодыг уншуулж, эрх зүйн цахим хөтөч аппликейшнаа татаарай.
GET IT ON Google play
Available on the App Store